

БАТЛАВ.  
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.БАДРАХБАЯР

**БҮЛГИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ**

2023 оны 01 дүгээр сарын 30

Улаанбаатар хот

**Нэг. Зорилго**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-т заасны дагуу Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрх, өрхийн гишүүн-иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох, төсөлд хамруулах, амьдрах ухаанд сургахад чиглэгдэнэ.

**2. Төслийг хэрэгжүүлэх зарчим**

- 2.1. Төслийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтлана.
- 2.1.1. Зорилтот бүлгийн иргэн сайн дурын үндсэн дээр төслийн үйл ажиллагаанд хамрагдана.
- 2.1.2. Төслийн үйл ажиллагаа адил тэгш, нээлттэй, ил тод байна.
- 2.1.3. Олон нийтийн оролцоонд тулгуурлана.

**Гурав. Төслийн хамрах хүрээ**

- 3.1 Төслийн сонгон шалгаруулалтад Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, өрхийн гишүүн-иргэн хамрагдана.
- 3.2. Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 18.2.9-т зааснаас бусад зорилтот бүлгийн өрхийн гишүүн, иргэн бүлгийн төсөлд хамрагдах тохиолдолд өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон амьжиргааны түвшин нь 409-өөс доош оноотой байх шалгуур тавихгүй.

**Дөрөв. Төсөлд тавигдах шаардлага**

- 4.1. Бүлгийн төслийг хүний нөөц, зах зээлийн болон эдийн засгийн тооцоо, судалгаа, төлөвлөгөөтэй боловсруулсан байна.
- 4.2. Төслийн талаарх мэдээлэлд дараахь зүйлийг тусгана:
  - 4.2.1. Төслийн товч агуулга;
  - 4.2.2. Төсөл хэрэгжүүлэгч иргэний нэр;
  - 4.2.3. Үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхлэх хаяг байршил, иргэний албан ёсны хаяг;
  - 4.2.4. Нийт санхүүжилтийн хэмжээ, түүнээс өөрийн оруулах хөрөнгийн хэмжээ;
  - 4.2.5. Үйлчилгээ, үйлдвэрлэл болон худалдах бүтээгдэхүүний нэр, төрөл;

**Тав. Төсөл хэрэгжүүлэгчид тавигдах шаардлага**

- 5.1. Бүлгийн төсөл хэрэгжүүлэгч нь өөрөө бие даан эсхүл гэр бүлийн гишүүд сайн дурын үндсэн дээр нэгдэн бүлэг болж өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байна.
- 5.2. Нэг өрхийн гишүүд тус тусдаа бүлгийн төсөлд хамрагдаж санхүүжилт авахыг хориглоно.

5.3. Төсөл хэрэгжүүлэх өрх, бүлэг нь сайн дурын үндсэн дээр нэгдсэн зорилтот бүлгийн 2 өрхийн 2 ба түүнээс дээш иргэний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүлгийн төсөлд хамрагдах өргөдөлд бүлгийн гишүүд гарын үсэг зурсан байна.

5.4. Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн баримт бичигт дор дурьдсан материалыг хавсаргана.

Үүнд:

5.4.1. Бүлгийн төсөлд хамрагдахыг хүссэн өрх, бүлгийн гишүүдийн өргөдөл

5.4.2. Төсөл

5.4.3. Өрх, бүлгийн гишүүдийн иргэний үнэмлэхний хуулбар

5.4.4. Төсөл хэрэгжүүлэх өрх, бүлгийн гишүүдийн оршин суугаа сум, баг, хорооны тодорхойлолт

5.4.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухайд хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлох баримт бичгийн хуулбар /Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр болон холбогдох бусад баримт бичгийн хуулбар байх бөгөөд эдгээрийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх/

5.4.6. Хүчирхийлэлд өртсөн иргэний тухайд хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон тухай Цагдаагийн байгууллагын тодорхойлолт эсхүл мэргэжлийн нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ, тодорхойлолт

5.4.7. Хорих ангиас суллагдсан иргэний тухайд ял шийтгэл эдэлж байгаад суллагдсан тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт

5.4.8. Согтуурах, мансуурах донтой өвчтэй, эдгэшгүй хүнд өвчтэй иргэний тухайд холбогдох нарийн мэргэжлийн эмчийн буюу эмнэлгийн байгууллагын дүгнэлт

5.4.9. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай өрх, иргэний тухайд Гэр оронгүй тэнэмэл амьдралтайг судлан тогтоосон мэргэжлийн нийгмийн ажилтны нөхцөл, байдлын үнэлгээ, тодорхойлолт

5.4.10. Шилжин суурьшсан өрхийн гишүүн-иргэн, иргэний тухайд шилжин суурьшсан нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай болохыг тодорхойлсон баг, хорооны засаг даргын тодорхойлолт

5.4.11. Өрх толгойлсон эх /эцэг/-ийн тухайд өрх толгойлсон тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт

5.4.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхийн тухайд 16 насанд хүрээгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлсон аймаг, дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын шийдвэрийн хуулбар байх бөгөөд эдгээрийн хүчинтэй хугацаа дуусаагүй байх

5.5. Бүлгийн төслийн сонгон шалгаруулалтад оролцож буй иргэн нь төслийн баримт бичгийн иж бүрдлийг цаасан болон "PDF" файл хэлбэрээр Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст ирүүлнэ.

### **Зургаа. Төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа**

6.1. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд бүлгийн төслийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл, сургалчилгааг олон нийтэд ил тод зарлах, сум, хороодын иргэдийн оролцоог жигд хангахад анхаарч төслүүдийг хүлээн авна.

6.2. Сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөл нь ирүүлсэн бүлгийн төслүүдийн материалтай танилцаж хурлаар хэлэлцэн дүгнэлт гарган, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст хүргүүлнэ. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрт бүлгийн төслийн ахлагч болон бүлгийн гишүүдийн мэдээллийг тусгаж өгөх шаардлагатай.

6.3. Бүлгийн төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн нийгмийн халамжийн хэлтэс, албаны дарга ахлах бөгөөд нарийн бичгийн даргаар нь Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн ажиллана.

6.4. Ажлын хэсэг нь тухайн аймаг, дүүргийн хүн амын тооноос шалтгаалж 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ирүүлсэн төсөл бүрийн хэрэгжих боломжийг газар дээр нь судалж, танилцан дүгнэлт, саналаа гаргасан байна.

6.5. Сум, баг, хорооны Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн бүлгийн төслийн материалыг хүлээж авахдаа Нийгмийн халамжийн нэгдсэн систем /E-halamj/ програмаас иргэний мэдээллийг шүүж, өмнө нь төсөлд хамрагдсан эсэхийг шалгаж нягтлана.

6.6. Бүлгийн төсөл нь аль болох бодитой хэрэгжих, төсөл хэрэгжүүлэгчийг /өрх, бүлгийг/ оновчтой сонгох зарчмыг баримталж, төслийг сонгон шалгаруулахдаа анхаарч ажиллах нь зүйтэй байна.

6.7. Бүлгийн төслийг сонгох шалгаруулах ажлын хэсгийн нийт гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн “Ашиг сонирхлын мэдүүлгийн маягт”-ыг бөглүүлж авсан байна.

6.8. Амьжиргааг дэмжих зөвлөлөөр дэмжигдсэн бүлгийн төслүүдийг Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нэгтгэн ажлын хэсэг төслүүдэд сонгон шалгаруулалт, үнэлгээ хийж дүгнэлт гарган, шалгарсан төслүүдтэй гэрээ байгуулна. Шалгарсан бүлгийн төслүүдтэй гэрээ байгуулсны дараа зохих санхүүжилтийг олгох, гэрээнд бүлгийн төслийн үйл ажиллагааны тайлан ирүүлэх хугацааг тодорхой зааж өгөх шаардлагатай.

6.9. Бүлгийн төслийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зарлаж, төслүүдийг хүлээж авах бөгөөд ажлын 10 хоногт багтаан сонгон шалгаруулалт хийж, гэрээ байгуулан, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

6.10. Шалгарсан төслүүдэд холбогдох журамд заасны дагуу мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгнө.

6.11. Бүлгийн төсөлд олгох санхүүгийн дэмжлэгийн дээд хэмжээ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/25 дугаар тушаалаар баталсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал”-ын 9.3-т заасны дагуу 2 сая төгрөг хүртэл байна.

6.12. Бүлгийн төсөлд хамрагдан санхүүгийн дэмжлэг авсан зорилтот бүлгийн иргэн 3 жилийн хугацаанд дахин хамрагдахгүй бөгөөд дахин хамрагдсан тохиолдолд төслийн үйл ажиллагааны чиглэл нь өөр байна.